

2026 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 26/001

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.9 дэх заалт, "Тэнгэр Даатгал" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 9.11 дүгээр зүйлийн 9.11.9 дэх заалтыг тус тус удирдлага болгон "Тэнгэр Даатгал" ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Тэнгэр Даатгал" ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг энэхүү тушаалын Хавсралт №1-т зааснаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ш. ГАНТУЯА

**Компанийн ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны
зардлын төсөв батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62.1 дүгээр зүйлийн 62.1.13 дэх хэсэг, “Тэнгэр Даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.11 дүгээр зүйлийн 9.11.7 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Тэнгэр Даатгал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг 2026 оны 03 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр баталсугай. Үүнд:

№	Зардлын төсөв	Нийт зардал (төгрөг)
1	ТУЗ-ийн дарга болон бусад найман гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарын цалин, урамшуулал	600,000,000
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурал	20,000,000
3	Бичиг хэрэг болон бусад	5,000,000
Нийт дүн		625,000,000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ш.ГАНТУЯА